



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

№140 /354/

2022.08.10

Цаг үе, үйл явдал

НҮБ-ЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА АНТонио ГУТТЕРИШ МОНГОЛ АХУЙ СОЁЛООР АМЬСГАЛСАН НЭГЭН ӨДРИЙГ ӨНГӨРҮҮЛЛЭЭ

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүхийн урилгаар НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гуттериш албан ёсны айлчлалыг эдгээр өдрүүдэд хийж байгаа НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гуттеришийг Монгол уламжлал, ахуй соёлтой танилцуулах, бэсрэг наадмыг Монгол Номадс жуулчны баазад зохион байгууллаа.

Тус арга хэмжээнд Батлан хамгаалах яамны сайд Г.Сайханбаяр, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Монгол Улс дахь НҮБ-ын суурин зохицуулагч Талан Мишра, БХЯ-ны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга Б.Бат-Эрдэнэ тэргүүтэй төлөөлөгчид байлцлаа.

Монгол улс цэнхэр дуулгатнаа олон улсын энхийг сахиулах ажиллагаанд илгээсний 20 жилийн ой энэ жил тохиож байгаа. Уг тэмдэглэлт түүхэн ойд зориулсан бэсрэг наадамд Цэргийн Дуу Бүжгийн Эрдмийн чуулгын хамт олон уртын дуугаа өргөж, ардын бүжгээ толилуулав. Мөн малчин айлд зочилж, монгол ахуй соёлтой танилцуулж, эрийн гурван наадмыг үзэж сонирхов.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гуттериш бэсрэг наадмыг үзэж сонирхсоны дараа "Халуун дулаанаар угтаж авсан Монгол орон мөн Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр танд гүн талархал илэрхийлье. Монголын түүх бол Зэвсэгт хүчний түүх гэдэгтэй энэ цаг мөчид санал нийлж буйгаа энд онцолъё.



Ийм баялаг түүх, зан заншилтай ард түмэн тэр дундаа Монгол Улсын Энхийг сахиулагчид бусад улс орны энхийг сахиулагчдаас эр зориг, шаламгай байдал, дайчин чанараараа үргэлж ялгарч байдаг гайхал зүйлгүй мэт санагдав.

Монгол Улсын энхийг сахиулагчдын дайчин эрэмгий байдал Монгол түмний цусанд байдаг аж. Үүнийг энэхүү бэсрэг наадмыг үзээд илүү ихээр ойлголоо" хэмээн сэтгэгдлээ хуваалцлаа.



БҮХНИЙГ ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ



Зэвсэгт хүчний 331 дүгээр анги
Зэвсэгт хүчний 331, 340 дүгээр ангийн албан тушаалын байрны гаднах "Хүүхдийн тоглоомын талбай"-г Зэвсэгт хүчний 331 дүгээр ангийн алба хаагчид шинэчлэн тохижууллаа. Энэ нь Монгол цэрэг энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж эхэлсний 20 жилийн ойн төлөвлөгөөний дагуу "Хүүхдийн тоглоомын талбай" тохижуулах

ажлыг хэрэгжүүлж, Уулын нэгдүгээр ротын тасгийн дарга ахлах ахлагч Б.Мөнхцэцэг ахлуулсан 10 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг тоглоомын талбайг шинэчлэн тохижуулж, ашиглалтад хүлээлгэн өглөө.

Мод, олс, дугуй ашиглан хашаа, мини хөл бөмбөгийн талбай, онгоц болон байшин хэлбэртэй элсний хайрцаг,

саравчтай иж бүрэн гулсуур, турник, савлуур зэрэг хүүхэд багачуудын биеийг чийрэгжүүлэх иж бүрдлээс гадна бяцхан хүүхдүүдийг тоглуулах дүүжин, анааш, тахь, мотоцикл, машин, сандал зэрэг аюулгүй олон тоглоомыг урлалаа.

Тус тоглоомын талбай нь эко модон тоглоомын талбай бөгөөд баруун хязгаарт алба хааж буй алба хаагчдын хүүхдүүдэд барьж буй том бэлэг боллоо.

Энэхүү хүүхдэд ээлтэй ажлыг Зэвсэгт хүчний 331 дүгээр анги

санаачлан, Зэвсэгт хүчний 340 дүгээр анги, оршин суугч алба хаагчдын дэмжлэг санхүүжилтээр гүйцэтсэн юм.

Мөн дээрх хоёр ангийн удирдлага болон сэтгэл зүрхээ шингээн ажилласан уран гарт залуустаа бяцхан үрсийнхээ өмнөөс талархал илэрхийлье.

Ахлах дэслэгч Б.ГЭРЭЛТ-ОД

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 22	🌙 10

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 29	🌙 23

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.190.00	3.200.0
EUR 🇪🇺	3.283.0	3.300.0
CNY 🇨🇳	473.00	476.00
RUB 🇷🇺	49.40	50.00
JPY 🇯🇵	23.40	23.80
KRW 🇰🇷	2.42	2.44

ЗУРХАЙ



2022.08.10 /ЛХАГВА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 13

ЗУНЫ АДАГ УЛААГЧИН ХОНЬ САРЫН ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ ХӨХӨГЧИН ХОНЬ ӨДӨР

Үс засуулбал:

ЖАРГАЛ ИРНЭ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

05.40-20.15

Барилдлага:

Идэр

Шүтэн барилдлага:

Авахуй

Суудал: Огторгуй

Энэ өдөр гахай, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, угаал үйлдэх, мал худалдан авах, мал түгээх, хийморийн дарцаг хатгахад сайн. Сахил санваар авах, хануур, төөнүүр хийлгэх, уул овоо тахихад муу.

Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал жаргал ирнэ.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 591,389,689

Эдгэрсэн

Нийт: 563,126,217

Нас барсан

Нийт: 6,442,061

Цахим шууданд

Д.Ариунболд: “АРАВТ”-ЫН НЭЭЛТ, ХААЛТЫН ЁСЛОЛООР МОНГОЛ МОРИНЫ ГАЙХАМШИГТ ҮЗҮҮЛБЭРИЙГ ТОЛИЛУУЛНА



“Аравт” олон улсын морин цэргийн уралдааны хүрээнд “Монголын морин урлагийн нэгдсэн холбоо” ТББ-ын зүгээс энэ сарын 13 болон 18-ны өдрүүдэд морин үзүүлбэрийн тоглолтыг зохион байгуулна. Энэ талаар тус холбооны тэргүүн Д.Ариунболдтой ярилцлаа.

Тус холбооны талаар танилцуулна уу?

-Манай холбоо Монгол эх орондоо болон гаднын улсуудад морин үзүүлбэр үзүүлдэг тамирчид, жүжигчдийн нэгдсэн байгууллага гэж ойлгож болно. Бид олон улсад зохион байгуулагддаг морин харва болон морин урлагийн олон тэмцээн уралдаануудад медальт байрт шалгарч байсан удаатай. Анх 2008 онд БНСУ-ын Чэжү арал дээр болсон морины шоу анх зохион байгуулж байлаа. Тус арга хэмжээнд долоон орны 120 адууг оролцуулж байсан удаатай. Түүнээс хойш манай залуучууд улс орон бүрээр аялан тоглолт хийсээр өнөөдрийг хүрчээ. Энэ жилийн хувьд манай хамт олон Тулгар төрийн 2231, Их Монгол Улс байгуулагдсаны 816, Ардын хувьсгалын 100, 101 жилийн ой болон эзэн Чингис хааны 760 насны ой давхацсан Үндэсний их баяр наадмын нээлтийн үйл ажиллагаанд томоохон ач холбогдол өгч оролцсон. Миний хувьд өөрөө эзэн

Чингис хааны дүрийг бүтээж морин үзүүлбэр үзүүлсэн.

М о р ь т о н залуучуудаараа дэлхийн тавцанд хүрч үзүүлбэр үзүүлдэг танай хамт олны зорилго юунд оршдог вэ?

-Бидний гол зорилго бол Монголын морины соёлыг дэлхийд таниулах юм. Бидний өв уламжлал, соёлын дархлаа гэдэг зүйл бол адуу юм гэдгийг монгол хүн бүхэн ухамсарлаасай гэж хүсдэг. Дээрээс нь “Аравт” олон улсын морин цэргийн тэмцээнийг дурдахгүй өнгөрч болохгүй. Монгол морины гайхамшигийг “Аравт” тэмцээн олон улсад харуулж байна. Бид цаашлаад дараа дараагийн тэмцээн, уралдааны хүрээнд бүтэн морьт ротын үзүүлбэрийг үзүүлэхээр удирдлагын түвшинд төлөвлөж байна.

“Аравт” олон улсын морин цэргийн уралдаанд хэрхэн оролцож байна?

-Бид тус тэмцээний нээлт болон хаалтын үйл ажиллагаанд оролцоно. Тодруулбал, нээлт, хаалтын ёслолын ажиллагаагаар уралдаанд оролцогч дөрвөн улсын морьтон дайчдад болон уригдсан хүндэт зочид төлөөлөгчдөд зориулан морин үзүүлбэр үзүүлэхээр бэлтгэл ажлаа хангаж байна. Энэ үйл ажиллагаанд манай байгууллагын шилдэг гэсэн 10 орчим жүжигчин оролцоно.

Олон улсын арга хэмжээний ёслолын ажиллагаа тул бидэнд алдах эрх байхгүй, хамгийн шилдэг үзүүлбэрээ толилуулахаар төлөвлөсөн. Үнэхээр гайхамшигтай үзүүлбэр үзүүлнэ. Монгол морьт, монгол залуус ямар гайхамшиг үзүүлэхийг та энэхүү уралдааны нээлт,

хаалтаас үзэх боломжтой. Дээрээс нь Зэвсэгт хүчний 232 дугаар ангийн алба хаагчидтай хамтран морин үзүүлбэр үзүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.

“АРАВТ-2022” УРАЛДААНЫ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БҮЛЭГ



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АНГИ БАЙГУУЛЛАГУУДЫН ТҮҮХТ ОЙН АРГА ХЭМЖЭЭНҮҮДЭД ТОГЛОЛТ УРАН БҮТЭЭЛЭЭ ТОЛИЛУУЛСААР БАЙНА

ЦДБЭЧ

Цэргийн чуулгын уран бүтээлч хамт олон энэ онд түүхт 100 жилийн ойтойгоо золгож буй Монгол Улс, Зэвсэгт хүчний Авто тээврийн анхны байгууллага Цэргийн гавьяаны улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 089 дүгээр анги, бахархалт

90 жилийн түүхээ бичиж буй Байлдааны гавьяаны Улаан тугийн одонт жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн баярын хүндэтгэлийн арга хэмжээнүүдэд идэвх санаачилгатай оролцож цэрэг эх орны, мөрдэс нэгт дайчдынхаа тухай

уран бүтээлүүдээ өргөн бариллаа.

“Их говийн гарнизон”, “Мөрдэстэй жолооч” гээд тэдний ажил үйлс, гавьяа алдрыг мөнхлөх уран бүтээлүүд чуулгын урын санд томоохон байр суурийг эзэлдэг билээ.

ХЭТ ХОЛЫН ЗАЙГ АМЖИЛТТАЙ ТУУЛЛАА



Зэвсэгт хүчний 331 дүгээр анги

Зэвсэгт хүчний 284 дүгээр ангийн Зураг зүйн техникч ахлах ахлагч Х.Гал-Эрдэнэ Шри Чинмойны нэрэмжит улсын аварга шалгаруулах 6, 12 болон 24 цагийн гүйлтийн тэмцээний 12 цагийн төрөлд 20-34 насны ангилалд амжилттай

оролцлоо. Тэр бээр энэ сарын 6-ны шөнийн 22 цаг 15 минутаас, 7-ны өглөөний 10 цаг 15 минут хүртэл 12 цагийн хугацаанд 101 километр 353 метр гүйж 5 дугаар байрыг эзэлжээ.

Ингэснээр Монгол Улсын хэт холын марафоны Улсын III зэргийн болзлыг хангалаа.

Ахлах дэслэгч М.ОЧГЭРЭЛ



Дарга, ерөнхий редактор, хурандаа **САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ**

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
“Соёмбо” сонин
“Дуулга” студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)